

DPUB

УЛААНБААТАР ХОТ ДАХЬ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН НИЙГМИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ ТӨСӨЛ




Мэдээллийн эмхтгэл №2

2017 он 10-р сар



Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс ХБИ-дэд зориулсан автомашины зогсоолтой боллоо

9-р сарын 7-ны өдөр Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET) зохион байгуулагдаж, тус хэлтсийн 33 албан хаагч хамрагдлаа. Сургагч багш Болороо (тархины саажилттай), Болдбаатар (харааны бэрхшээлтэй) нар сургалтыг чиглүүлэн явуулсан бөгөөд оролцогчид “Бэрхшээл” хаана байна вэ? гэсэн асуудлын талаар ярилцсанахаа дараа “Чингэлтэй дүүргийг хэрхэн хүртээмжтэй болгох” талаар санал солилцлоо. Тус сургалтанд Уянгасайхан (тархины саажилттай), Чулуун-Эрдэнэ (хөдөлгөөний бэрхшээлтэй) нар багуудын чиглүүлэгчээр оролцов. Сургалтанд оролцогчид хаалганы босго, налуу замын стандарт, дохионы хэл мэддэг ажилчдын тоо хангалтгүй гэх мэт олон асуудлуудыг дэвшүүлж, өөрсдийн оролцоотойгоор шийдвэрлэх боломжтой асуудлуудыг жагсааж бичлээ. Үүнээс хойш хэсэг хугацааны дараа “ХБИ-дэд зориулсан автомашины зогсоол”-ын асуудлыг шийдэж чаджээ. Энэ нь өдөр тутам автомашины зогсоолын асуудалтай тулгардаг ХБИ-ийн хувьд тун талархуштай явдал боллоо. Хүртээмжтэй орчныг бүрдүүлэхэд шаардлагатай төсөв, санхүү хязгаарлагдмал хэдий ч Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн ажилчид “Ээлтэй орчинг бүрдүүлэх” зорилгоор хүчин чармайлт гарган ажиллаж байна.



Дэйзи (ярьдаг) номыг танилцуулах уулзалт зохион байгуулагдлаа

10-р сарын 11-ний өдөр оюуны бэрхшээлтэй залуучуудад /нийт 11 хүн/ зориулан монгол хэлээр ярьдаг зурагт номыг танилцууллаа. Уулзалтанд эдгээр залуучуудаас гадна “Эцэг, эхчүүдийн холбоо”, “Солонго” ТББ-уудын төлөөлөл, монгол хэлээрх дэйзи номыг бэлтгэн гаргасан МХҮХ-ны ажилтан Гончигдорж, ХНХЯ-ны ахлах мэргэжилтэн Ганболд, ЖАЙКА-ийн сайн дурын гишүүн Мацүмото, төслийн мэргэжилтэн Исобэ нар оролцлоо. Тус уулзалтан дээр “Kasajizou /Малгайтай чулуун бурхан” гэдэг Япон үлгэрийн монгол хэлээрх хувилбарыг залууст үзүүлсний дараа дэйзи номыг шимтэн унших дуртай Заяа өдөр тутам дэйзи номыг хэрхэн ашиглаж байгаагаа бусаддаа танилцууллаа. Түүнчлэн уулзалтанд оролцсон ТББ-ын холбогдох хүмүүс “энэ номыг хүнд хэлбэрийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үзүүлэх”, “дэйзи ном уншсанаар хүүхдийн дуудлага илүү сайжрах юм байна” гэх мэтээр саналаа илэрхийлж байлаа.



Монгол хэл дээрх 2 дахь Дэйзи зурагт ном “Цэг, цэг” бэлэн боллоо. Номыг бэлтгэн гаргасан Хараагүйчүүдын Үндэсний Холбооны Гончигдоржид талархснаа илэрхийлье. Төслийн хүрээнд энэ номыг 11-р сарын 10-нд Дауны холбоон дээр анх удаа нийтийн хүртээл болгохоор төлөвлөөд байна.

100 дахь удаагийн DET сургалт

Энэ жилийн 1-р сараас зохион байгуулагдаж эхэлсэн Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET) 10-р сарын байдлаар нийтдээ 100 удаа зохион байгуулагдаж, 3000 гаруй оролцогчид хамрагдаад байна. “Орчны нөхцөл байдал сайжран, ялгаварлан гадуурхах явдал байхгүй болсоноор бэрхшээлийн асуудал шийдэгддэг юм байна” гэдгийг хүмүүст ойлгуулахын тулд төрийн байгууллага, сургууль, бизнесийн байгууллагуудад DET сургалтыг зохион явуулж байгаа билээ. 10-р сарын 26-ны өдөр Хүүхдийн тусламжийн утас-108 төвийн албан хаагчид сургалтанд хамрагдсан бөгөөд энэ үеэр Японоос сар тутам хэвлэгдэн гардаг “Mundi” сэтгүүл /олон улсын хамтын ажиллагааны тухай нийтлэл гардаг/-ийн сурвалжлагч ирж ярилцлага авлаа. Ярилцлагын үеэр “Сургагч багш болсноосоо хойш завгүй байдаг болсон бөгөөд олон хүний өмнө чөлөөтэй ярьж чаддаг болсон” гэх мэт олон ахиц дэвшилт гарсныг сургагч багш нар өгүүлж байлаа.



Хөгжлийн бэрхшээлтэй манлайлагч залуучуудад зориулсан 2 дахь удаагийн хичээл

Энэ удаагийн хичээлээр түүхэнд хамгийн сүүлчийн иргэний эрхийн хөдөлгөөн гэж нэрлэгддэг Америкийн ХБИ-ийн хөдөлгөөний талаар заалаа. Тухайлбал бие даан амьдрах хөдөлгөөн, Сэргээн засах хуулийн 504-р зүйл, Америкийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (ADA) батлагдах үйл явц, тухайн үед өрнөж байсан хөдөлгөөнүүдийн үүрэг, ололт амжилт зэргийн талаар тайлбарлалаа. Америкт ХБИ-ийн хөдөлгөөн нэлээд хүчтэй өрнөсөн учраас Япон улс ч гэсэн жишиг болгон ашигладаг. Энэ талаарх мэдээлэл Монгол улсын ХБИ-дэд ч гэсэн хэрэг болно гэж бодож байна. Тус хичээл нь “Хөгжлийн бэрхшээлтэй манлайлагч залуучуудад зориулсан хичээл” боловч төр, төрийн бусын ажилтан, халамжийн үйлчилгээний чиглэлээр ажилладаг хүмүүс ч гэсэн оролцох боломжтой. Энэ удаагийн хичээл ч танхим дүүрэн хүнтэй байсан бөгөөд сургалтанд оролцсон нийт 60 оролцогчдод төслийн зүгээс талархаж байгаагаа илэрхийлэе.



Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан япон хэлний сургалт эхэллээ

Япон хэлний сургалтын анхны хичээл 10-р сарын 22 (Ням)-ны өдөр МХҮХ-ны дэргэдэх Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд эхэллээ. Тус сургалтанд 3 хүн хамрагдсан бөгөөд мэндчилгээний үг хэллэг, ангид хэрэглэгдэх үг, хирагана үсгүүдийг зааж эхэлсэн байна. Төслийн зүгээс хичээл заасан Сайто багш, Ватанабэ багш, мөн хамтран ажилласан захирал багш Ганзориг, Мандах багш нарт талархаж байгаагаа илэрхийлэе. Сургалтанд оролцогч залуучууд маань япон хэлээ амжилттай сурч цаашдаа Япон улсад суралцах зам нь нээлттэй болно гэдэгт итгэлтэй байна.



29-р сургууль (Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургууль)-ийн сурагчидтай уулзлаа

Ирэх жил сургуулиа төгсөх ахлах ангийн сурагчдад зориулж боловсрол эзэмшихийн давуу тал, цаашид нийгэмд хэрхэн ажиллаж амьдрах талаар Япон улсын жишээн дээр тулгуурлан яриа хийлээ. Төслийн зүгээс эхлээд “Хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загвар”-ын талаар тайлбарлаж, улмаар төслийн зорилго болох “нийгмийн саад”-ыг арилгах чиглэлээр явуулж буй үйл ажиллагаанууд, түүнчлэн төр, ТББ-уудтай хэрхэн хамтран ажиллаж байгааг танилцууллаа. “Хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загвар”-ын талаар анх удаа сонссон сурагчид олон байсан төдийгүй хөгжлийн бэрхшээл нь хувь хүндээ биш, нийгэмд байгаа гэсэн яриаг сонсоод энэ талаар илүү дэлгэрэнгүй судалж мэдэхийг хүсэж байгаагаа илэрхийлж байв. Сурагчдыг “Хөгжлийн бэрхшээлтэй залуу манлайлагчдад зориулсан цуврал лекц”-д оролцохыг урьж, мөн “DASUKIN” хөтөлбөрийн тухай танилцууллаа. Сурагчидтай халуун дотно яриа өрнүүлэх боломж олгосон Дуламсүрэнд талархаж буйгаа илэрхийлэе.



Сайн байцгаана уу, энэ дугаараараа ч гэсэн та бүхэнтэй мэндчилж байгаадаа баяртай байна. Япон хүний хувьд хамгийн хэцүү санагддаг хүйтний улирал хаяанд ирлээ... Хүмүүс Намайг “Хөгжиж буй орны ХБИ-ийг дэмжиж ажилладаг ямар мундаг юм бэ” гэж хэлэхэд нь би жаахан тэвддэг. Би өөрөө өөрийгөө огтхон ч тэгж боддоггүй. Би хэн нэгэн сул дорой хүмүүсийг авардаг баатар ч биш. Зүгээр л урд нь сонссон “ХБИ амьдрахад таатай нийгэм гэдэг нь бүх хүмүүст амьдрахад таатай нийгэм” гэдэг үг надад их нөлөөлсөн. Бодоод үзэхээр үнэхээр л тийм байгаа биз. ХБИ амьдрахад таатай байвал бусад хүмүүсийн хувьд ч гэсэн амьдрахад таатай нийгэм гэсэн үг биз дээ? Тэгэхээр миний ажил бол бүх хүмүүст таатай нийгмийг бий болгох, өөрөөр хэлбэл нийгмийг хөгжүүлэх төсөл юм. Тэгж бодохоор сэтгэл хөдлөхгүй байхын аргагүй байгаа биз дээ. Би өөрөө ч гэсэн энэ үгэнд их дуртай. Ийм нийгмийг бүтээдэг ажил гээд бодохоор их сайхан санагддаг. Цаашид ч гэсэн Монгол улсын бүх хүмүүс амьдрахад таатай нийгмийг бий болгох зорилготойгоор ажиллах болно.



DPUB ахлах зөвлөх Чиба Хисао

Хаяг: Монгол улс, Улаанбаатар-15160, Нэгдсэн үндэстний гудамж-5, Засгийн газрын 2-р байр, ХНХЯ

Фэйсбүүк хуудас: <https://www.facebook.com/jicadpub>

Цахим хуудас: <https://www.jica.go.jp/project/mongolia/015/index.html>

И-мэйл: dpub.jica@gmail.com